



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 361

Улаанбаатар хот


Даатгуулагчдад сугалаа, бэлэг, урамшуулал
олгохыг хориглох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд тээврийн хэрэгслийн өмчлөгч, жолооч нарыг хамруулах зорилгоор даатгалын компаниас аливаа хэлбэрээр азтан шалгаруулах, сугалаа гаргах, бэлэг, урамшуулал олгох, хөнгөлөлт үзүүлэх зэрэг арга хэмжээ зохион байгуулахыг 2012 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хориглосугай.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д. БАЯРСАЙХАН

001397